

С ХЭСЭГ: НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

БҮЛЭГ С7: ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ

Агуулга

7. ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
7.1. ТАНИЛЦУУЛГА	2
7.2. ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ	2
7.2.1 Орон зайн хамрах хүрээ	2
7.2.2 Цаг хугацааны хамрах хүрээ	2
7.3. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ	2
7.3.1 Нөлөөллийн тойм	2
7.3.2 Монгол улсын үндэсний эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	3
7.3.3 Үнийн инфляци ба амьжиргааны өртгийн өсөлт	9
7.3.4 Улсын төсөвт оруулах орлогын өсөлт	13
7.4 ҮЛДЭГДЭЛ НӨЛӨӨЛЛИЙН ТОЙМ	17

Зургийн жагсаалт

Зураг 7-1: Стандарт тохиолдол болон Оюу Толгой төсөл хэрэгжих нөхцөлд нэг хүнд ногдох Монголын бодит ДНБ, төгрөг	5
Зураг 7-2: Монгол улсын засгийн газрын төсвийн орлого	6
Зураг 7-3: Монгол улсын инфляцийн динамик, 2008-2011	10
Зураг 7-4: Оюу Толгойн нийт татварын төлбөр, 2000-2010*	15

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 7-1: Барилгын ажлын үе шатны эдийн засгийн болон санхүүгийн үзүүлэлтүүд	4
Хүснэгт 7-2: Үйлдвэрлэлийн үе шатны эдийн засгийн болон санхүүгийн үзүүлэлтүүд	Error!
Bookmark not defined.	
Хүснэгт 7-3 Монгол төгрөгийн ханш (₮/US\$, улирлын эцэст)	7
Хүснэгт 7-4: 9000 ам.долларын зах зээлийн үнэтэй зэсийн ордын төслийн нөөц ашигласны төлбөрийн судалгаа	13
Хүснэгт 7-5: Эдийн засгийн нөлөөллийн тойм	18

7. ЭДИЙН ЗАСАГТ НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

7.1. ТАНИЛЦУУЛГА

БОННБУ –ий энэ бүлэг нь Оюу Толгой төслийн Монгол улсын үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг авч үзэж байна. Энэ бүлэг нь Оюу Толгой төслийн Нийгэм-эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ (НЭЗНБУ) болон Оюу Толгой ба Рио Тинто Холдингс ХХК –ний саяхан хийсэн эдийн засгийн шинжилгээнд тулгуурласан болно^{1,2}. Эдийн засгийн нөлөөлөлд макро эдийн засгийн нөлөөлөл, Монгол улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) –д орсон өөрчлөлт, инфляци, эдийн засгийн өсөлт, хэрэглээний бүтэц ба хөрөнгө оруулалтын түвшин болон микро эдийн засгийн үзүүлэлтүүдийг авч хэлэлцсэн.³

Төслийн барилгын шат хэрэгжиж байгаа тул зарим холбогдох эдийн засгийн нөлөөллүүд нь юуны түрүүнд татвар болон бусад заавал төлөх төлбөр зэрэг улсын төсөвт орсон орлогоор хэдийнээ илэрч эхэлсэн бөгөөд хэрэглэгчдийн үнийн инфляци үүссэн (гэхдээ Оюу Толгой төслийн нийт үнийн инфляцид нөлөөлөх нөлөөлөл нь энэ шатанд Засгийн газрын статистикаар тодорхойлогдож чадахгүй). Төслөөс үзүүлэх эдийн засгийн өөрчлөлтийн өөр нэг эерэг тал нь Оюу Толгой төсөл идэвхитэй хэрэгжих болсон үеэс эхлэн Ханбогд суманд худалдан авч болох барааны нэр төрөлд нилээд өсөлт тэмдэглэгдсэн байна.

Үйлдвэрлэлийн урт хугацааны хөгжлийн үе шатанд Оюу Толгой төсөл нь зөвхөн үндэсний эдийн засагт түлхэц өгөөд зогсохгүй Төслийн нөлөөллийн бүсийн хүрээнд Өмнөговь аймаг ба орон нутгийн сумдын эдийн засгийг бэхжүүлэхэд нилээд хэмжээгээр хувь нэмэр оруулна гэж таамаглаж байна. Төслөөс санхүүжүүлсэн бүс нутгийн ба орон нутгийн шууд санхүүжүүлэлтээс гадна засгийн газрын зүгээс Төслөөс үүссэн төвлөрсөн хөрөнгийг үр дүнтэйгээр хуваарилах нь эдийн засгийн амжилттай өгөөжийг тодорхойлох үндсэн хүчин зүйлүүдийн нэг юм.

7.2. ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

7.2.1 Орон зайн хамрах хүрээ

Энэхүү үнэлгээ нь үндэсний эдийн засаг, төслийн нөлөөллийн бүс болон орон нутгийн түвшин дэх эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал болон Өмнөговь аймгийн эдийн засгийн хандлага, өөрчлөлтийн талаар авч үзэж, үнэлсэн. Үнэлгээний үр дүнгээр Өмнөговь аймаг, үүний дотор аймгийн төв Даланзадгад хот төдийгүй улсын хэмжээнд эдийн засгийн чухал нөлөөлөл үүсэх нь тодорхой болсон. Төслийн эдийн засгийн нөлөөллийн орон нутагт үзүүлэх эерэг үр шимийг Оюу Толгой төсөл байрлах Ханбогд сум төдийгүй бусад ойролцоох сумдад ч мөн хүртээх болно.

7.2.2 Цаг хугацааны хамрах хүрээ

Цаг хугацааны хамрах хүрээ нь төслийн барилгын шатаас эхлээд үйлдвэрлэл ба хаалтын үе шатыг уурхайн дараах үлдээсэн өв хөрөнгөтэй хамтад хамрах болно.

7.3. НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Бүлгийн дараах хэсгүүдэд Оюу Толгой төслийн боломжит нөлөөллүүд, тэдгээрийг бууруулах төлөвлөсөн болон одоогийн хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг өгүүлсэн болно. Нөлөөлөл болон түүний зэрэглэлийн талаар Хүснэгт 7-4-д дэлгэрэнгүй үзүүлсэн.

7.3.1 Нөлөөллийн тойм

Оюу Толгой Төслийн зүгээс эдийн засагт дараах гол нөлөөллүүдийг үзүүлэх төлөвтэй байна. Үүнд:

¹ Оюу Толгой төслийн Нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ, Эцсийн тайлан, 2009 оны 9 – р сар. Бодлого судалгааны төв, Хүн амын сургалт судалгааны төв, Монгол улсын их сургуулийн Эдийн засгийн сургууль. 60 – р хуудас.

² Оюу Толгойн зэсийн уурхайн хөгжил: Монголын макро эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, 2011 оны 2 – р сар. Монгол улсын их сургуулийн Эдийн засгийн сургууль ба Би Эй Экономикс ХХК.

³ Эх сурвалж: Бизнесийн толь бичиг, <http://www.businessdictionary.com/>

- Макро эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, ДНБ-ний өсөлт (үндэсний ба нэг хүнд ногдох), улсын төсвийн нэмэгдсэн орлого ба валютын ханшийн бууралт, төгрөгийн өсөлт зэргээр дамжуулан үндэсний эдийн засагт нөлөөлөх байдал;
- Орон нутгийн төсвийн өсөлт, хүн амын орлогын өсөлт болон хадгаламж, зээлийн үйлчилгээний нөхцөл сайжирсан зэргээс шалтгаалсан үнийн өсөлт ба амьжиргааны өртгийн өсөлт зэрэг инфляцийн нөлөөллүүд; ба
- Татвар болон бусад заавал төлөх төлбөр хураамжаар дамжуулан улсын төсвийн орлого нэмэгдэх.

7.3.2 Монгол улсын үндэсний эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Нөлөөллийн тодорхойлолт

Оюу Толгой бол дэлхий дээрх хараахан олборлож эхлээгүй зэсийн хамгийн том орд юм. Энэ Төсөл бол эдийн засгийн үнэлгээний хувьд Монгол улсын хамгийн том ашигт малтмалын төсөл бөгөөд үндэсний эдийн засгийн хувьд дараах нөлөөллүүдийг үзүүлэх болно:

- Монгол улсын ДНБ ихээхэн өсгөх бөгөөд энэ нь тодорхой хугацааны туршид дэд бүтцийн салбарт хийх (тээвэр, нийтийн аж ахуйн ба нийтийн ахуй үйлчилгээ, сургалт г.м.) хөрөнгө оруулалтын байнгын урсгалыг бий болгох ба нэг хүнд ноогдох ДНБ – ийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах болно;
- Валютын ханшийн өсөлт, энэ нь үнийн өсөлтийн улмаас улсын экспортын хэмжээнд болон үнийн өсөлтөөр өдөөгдсөн импортын өсөлтөнд сөргөөр нөлөөлөх боломжтой; бөгөөд
- Уул уурхайн салбарын урт хугацааны өсөлт ба түүний улсын эдийн засагт өсөн нэмэгдсэн давамгайлал, энэ нь хөдөө аж ахуй болон боловсруулах үйлдвэрийн салбарыг удаашруулж бууруулахад хүргэх талтай боловч уул уурхайн салбарт олон улсын хөрөнгө оруулалтыг татах нь ажил эрхлэлт ба барааны эрэлт хэрэгцээ, үйлчилгээ зэргээр эдийн засгийн бусад салбарт шууд бус ашигтай илүүдэл урсгал орох үр нөлөөтэй байж болно.

ДНБ – ний өсөлт

Барилгын шат нь 2009 онд Хөрөнгө оруулалтын гэрээ (ХӨОГ) – г байгуулж, 2010 оны барилгын ажлын 915 сая ам.долларын төсвийг баталснаар эхэлсэн. Дэлхийн банкны хамгийн сүүлийн үеийн мэдээгээр⁴ Монгол улсын 2'670'966 хүн амд үндэслэсэн 2009 оны ДНБ – ийг 4'202'494'302 ам.доллар гэсэн тоогоор илэрхийлж байна. Барилгын шатанд Монгол улсад орох жилийн дундаж мөнгөний урсгалд үндэслэн ХНТ 10–ын⁵ урьдчилсан тооцоогоор Оюу Толгой төслийн барилгын ажил (үйлдвэрлэл эхлэхээс өмнө) нь улсын ДНБ – ыг ойролцоогоор **15% - аар нэмэгдүүлнэ** гэж багцаалж байна.

Барилгын ажлын хурдасгасан графиктай холбоотойгоор Төслийн бодит зардал нэмэгдсэн бөгөөд ажиллах хүчний тоо санхүүгийн анхны загварын таамаглалд хэрэглэгдэж байснаас хэтэрсэн (2011 оны 12 сарын байдлаар төсөлд нийт 15,000 орчим хүн ажиллаж байна). ХНТ10–ын санхүүгийн төсөвлөлт нь одоо 2012 оны эхээр эхэлнэ гэж төлөвлөж байгаа 2013 оны ашиглалтанд оруулж эхлэх тооцоонд үндэслэгдсэн болно. ХНТ10 – д оруулсан илүү их баримжаалсан төсөвлөлт дээр үндэслэн доорхи хүснэгтэнд Оюу Толгой төслийн барилгын шатны үйл ажиллагааны эдийн засгийн болон санхүүгийн гол үзүүлэлтүүдийг тоймлон харуулсан байна.

⁴ <http://data.worldbank.org/country/mongolia>

⁵ Хөгжлийн нэгдсэн төлөвлөгөө 2010 (ХНТ 10) – Оюу Толгой Төслийн тухай АМЕК Минпрок ХХК – ийн бэлтгэсэн техникийн бие даасан тайлан.

Хүснэгт 7-1: Барилгын ажлын үе шатны эдийн засгийн болон санхүүгийн үзүүлэлтүүд (ХЦТ10-аас иш татсан)

Үзүүлэлт	Тооцсон үнэ (ам.доллар)
Барилгын шатанд улсын төсөвт орох орлогын нийт дүн (2012 оны хоёрдугаар хагасын төгсгөл гэхэд)	649,294,000
Барилгын шаттай холбоотой Монголын ажиллах хүчинд зарцуулах зардал/цалин	160,987,000
Барилгын шатанд Монгол улсад үйлдвэрлэсэн бараа үйлчилгээнд зарцуулсан зарлага	1,150,065,000
Барилгын шатанд Монгол улсад оруулах нийт мөнгөний урсгал	1,960,346,000

Тайлбар: Бүх зардал 2010 оны үнэлгээгээр байгаа бөгөөд хөнгөлөлтийн хувь тооцогдоогүй болно. Түүнчлэн барилгын ажлыг 2012 оны 7 сард дуусахаар, үйлдвэрлэлийн үе шат 2012 оны төгсгөлд эхлэхээр тооцолсон.

ДНБ–ний өсөлт нь барилгын ажлын шатанд Оюу Толгой төслөөс орох орлогоор дэмжигдэн үргэлжлэх төлөвтэй байна.


Нэг хүнд ногдох ДНБ –ний өсөлт

Оюу Толгойн Эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээгээр⁶, Төсөл нь 2020 он гэхэд Монгол улсын эдийн засгийг 35 гаруй хувиар өсгөнө гэж урьдчилан таамаглаж байна. Нэг хүнд ногдох ДНБ – ийг 2020 он гэхэд 1,7 сая төгрөгөөр (1000 гаруй ам.доллараар) өсгөнө гэж төлөвлөсөн байна – энэ нь өнөөдрийн нэг хүнд ногдох ДНБ – ний 60 гаруй хувьтай тэнцэх өсөлт⁷ юм. 2043 он гэхэд нэг хүнд ногдох бодит ДНБ нь доорхи Зураг 7-1 –д үзүүлснээр 4,67 сая төгрөг (3'510 ам.доллар) – өөр нэмэгдэхээр урьдчилан таамагласан байна. Тийм учраас Оюу Толгой төсөлтэй холбоотойгоор хүлээгдэж байгаа эдийн засгийн үр дүнгийн хэмжээ далайц нь үндэсний хэмжээнд мэдэгдэхүйц байна.

⁶Оюу Толгойн зэсийн уурхайн хөгжил: Монголын макро эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, 2011 оны 2 – р сар. Монгол улсын их сургуулийн Эдийн засгийн сургууль ба Би Эй Экономикс ХХК.

⁷ 2009 онд Монгол улсын нэг хүнд ногдох ДНБ 1,560 ам.доллар байсан. Эх сурвалж: дээр дурьдсанчлан. Дэлхийн Банкны мэдээгээр уг үзүүлэлт 2010 онд 2,207 ам.доллар болж өссөн байна. Эх сурвалж: <http://data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.CD>

Зураг 7-1: Стандарт тохиолдол⁸ болон Оюу Толгой төсөл хэрэгжих нөхцөлд нэг хүнд ногдох Монголын бодит ДНБ, төгрөг



Эх сурвалж: Олон улсын валютын сан (ОУВС)⁹, Оюу Толгойн эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ

Улсын орлогын өсөлт


Төслөөс оруулж байгаа орлогын ихэнх хувь нь Монголын Татварын ерөнхий хуулийн дагуу төв засгийн газрын төсөвт орох болно. Төсөл нь 2020 онд татвар болон ноогдол ашгийн хэлбэрээр улсын орлогын 30 гаруй хувийг дангаараа бүрдүүлэх болно. Зураг 7-2– т үзүүлснээр 2043 онд Монгол улсын Засгийн газрын төсвийн орлого нь баялаг хуримтлуулах нөхцөлд 10 их наяд төгрөгт (ойролцоогоор 7,5 тэрбум ам.долларт) ба бэлэн мөнгө хуваарилах нөхцөлд 9,3 их наяд төгрөгт (ойролцоогоор 7,0 тэрбум ам.долларт) хүрэх төлөвтэй байна¹⁰ (цаашид дэлгэрэнгүйг 7.3.4 – р хэсэг “Улсын төсвийн орлогын өсөлт” – ээс үзнэ үү).

⁸ Стандарт тохиолдол гэдэг нь 2004 ба 2043 оны хоорондох бүс нутаг тус бүрийн хүн ам, ажиллах хүч ба эдийн засгийн өсөлт түүнчлэн Монголын салбарын бүрэлдэхүүн хэсгийн үйлдвэрлэл, хадгаламж ба уул уурхайн үйлдвэрлэлийн иж бүрэн төсөвлөлт юм. Дэлхийн өргөн хэрэглээний барааны тухай таамаглалыг бас хийсэн. Монголын эдийн засаг Оюу Толгойн оролцоогүйгээр урагшилж байгаа тохиолдолд reference case нь ‘business-as-usual’ scenario байна. Цаашид дэлгэрэнгүйг Оюу Толгойн эдийн засгийн нөлөөлийн үнэлгээнээс үзнэ үү (энэ тухай дээр ярьсан).

⁹ ОУВС, Дэлхийн эдийн засгийн хэтийн төлвийн мэдээллийн сан, Дэлхийн эдийн засгийн ба санхүүгийн судалгаа (онлайн). Эх сурвалж URL: <http://www.imf.org/external/pubs/ft/weo/2009/02/weodata/index.aspx> [2010 оны 10 – р сарын 14 – нд нээгдсэн], Оюу Толгойн эдийн засгийн нөлөөлийн үнэлгээнд яригдсан.

¹⁰ Баялаг хуримтлуулах нөхцөл гэдэг нь Оюу Толгой төслөөс засгийн газарт төлөх татварын орлогыг бүгдийг нь улсын төсөвт хадгалах таамаг бодлогын загварчлал юм. Нийт орлогыг бүхлээр нь хадгалах бөгөөд хадгаламжийн хүү нь айл өрхүүдэд тараагдах буюу засгийн газрын зарцуулалтад ашиглагдана. Бэлэн мөнгө тараах нөхцөл гэдэг нь Оюу Толгой төслөөс засгийн газарт төлсөн нийт татварыг айл өрхүүдэд хувийнх зарлагад болон хадгаламжинд зориулан бүгдийг тараах таамаг бодлогын загварчлал юм. Дэлгэрэнгүй мэдээллийг Оюу Толгой төслийн Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээний тайлангаас харна уу.

Зураг 7-2: Монгол улсын засгийн газрын төсвийн орлого



Эх сурвалж: Оюу Толгойн эдийн засгийн нөлөөлийн үнэлгээ 2011

Валютын ханшийн өсөлт

Оюу Толгойн эдийн засгийн нөлөөлийн судалгаагаар Төсөл нь 2020 он гэхэд бодит валютын ханшийг *Ердийн нөхцөл* –тэй харьцуулахад /өөрөөр хэлбэл Оюу Толгой төсөл хэрэгжихгүй тохиолдолд юу болох вэ гэдэгтэй харьцуулахад/ ойролцоогоор 15% -аар өсгөхөд хүргэнэ гэж урьдчилан таамагласан боловч өсөлтийн бодит хэмжээ нь зэсийн үнэ ба засгийн газрын холбогдох бодлогоос хамаарна. Үүний зэрэгцээ дотооддоо үйлдвэрлэсэн барааг импортын бараагаар орлуулах нь солилцооны үнийн өсөлттэй холбоотойгоор үндэсний экспортын эрэлт хэрэгцээг бууруулах эрсдэлтэй ба дотоодын үйлдвэрлэлийн барааны худалдаа/экспортын өрсөлдөх чадварийг багасгаж эдийг засагт таагүй нөлөөлөл үзүүлэх магадлалтай юм. “Голланд өвчин” гэдгээр дэлхий нийтэд мэдэгдэх болсон энэ нөлөөллийг цаашид *Бүлэг С13: Хуримтлагдах нөлөөлөл бүлэгт* хэлэлцэх болно.

Импортын үнэлгээ буурахын хамтаар төгрөгийн ханшийн чангаралт болон улсын экспортын бүтээгдэхүүний өндөр үнийн шууд харьцааны улмаас зарим нэг сөрөг үр дагавар үүсэх магадлалтай. Уул уурхайгаас гадна Монгол улсын үндэсний гол нэрийн экспортын бүтээгдэхүүнд ноос, ноолууран эдлэл болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хамаарна. Уул уурхайн салбарын хөгжилтэй уялдан үүсэх төгрөгийн өсөлт, бараа бүтээгдэхүүний үнийн нэмэгдэл нь эдгээр үндэсний бүтээгдэхүүнд сөрөг нөлөөг үүсгэх талтай. Оюу Толгой, Таван Толгой зэрэг төслүүдийн хэрэгжилтийн үр дүнд төгрөгийн ханш хэдэн арав дахин өсөх магадлалтай байна¹¹. Гадаад бараа, бүтээгдэхүүний зах зээлд найдах нь улсын эдийн засгийн тогтвортой бус байдал буюу хэлбэлзлийг үүсгэнэ. Зэсийн үнэ урт хугацаанд бага байх тохиолдолд үндэсний төгрөгийн ханш төдийлөн чангарахгүй.

Үүсэх магадлалтай төгрөгийн ханшийн өөрчлөлтийг

¹¹ *Монгол улсы анхны доллараа худалдаалж 500 сая ам доллар босгосон нь*. Ю.Хумбер, К.Николас. 2011 оны 3 сарын 3. Эх сурвалж: <http://www.bloomberg.com/news/2011-03-02/mongolia-plans-to-raise-500-million-in-first-dollar-bond-sale.html>

Хүснэгт 7-2 Монгол төгрөгийн ханш

Хүснэгт 7-2-д харуулав.

Хүснэгт 7-2 Монгол төгрөгийн ханш (₮/US\$, Хугацааны төгсгөлд)

2006	2007	2008	2009	2010	2011 (11 сарын 2-ны байдлаар)
1165	1170	1267.5	1443.6	1257.18	1300.32

Эх сурвалж: 2006-2009 – Дэлхийн Банкны Зүүн Ази болон Номхон далайн орнуудын эдийн засгийн шинэчилсэн мэдээлэл 2010 оны 10 сар. Дугаар 2. Улсын мэдээлэл, гол үзүүлэлтүүд: Монгол улс. * Эх сурвалж: Монгол улсын төв банкны мэдээлэл¹²

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт, бараа, бүтээгдэхүүнд тулгуурласан экспортоос орж ирэх орлого төгрөгийн ханшийг нэмэгдүүлснээр үндэсний эдийн засгийн салбарын бүрдүүлэлтэд нөлөөтэй байх талтай. Энэ тохиолдолд уул уурхайн салбарын өсөлт, тэр дундаа Оюу Толгой төслийн улмаас 2020 он гэхэд 2 дахин нэмэгдэх¹³ эдийн засгийн өсөлт нь уул уурхайн бус салбаруудын ажиллах хүчний зардлыг нэмэгдүүлэх талтай.

‘Голланд өвчин’ хэмээх тодотголтой нөхцөл үүсэхээс сэргийлэх, эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг бий болгохын тулд Монгол улсын засгийн газраас уул уурхайн бүс бусад салбарыг давхар дэмжин ажиллаж байгаа бөгөөд эдгээрээс дурдвал: хүнс үйлдвэрлэл, метал баяжуулалт, аялал жуулчлал гэх мэт. Үүний нэг жишээ нь, Монгол улсын засгийн газраас малчдыг дэмжиж, тэдний бүтээгдэхүүнийг гадаад, дотоодод сурталчилах замаар ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж буй явдал юм. Ингэхдээ гадаад зах зээлд дан ганц үнийн хувьд өрсөлдөхөөсөө илүүтэй бүтээгдэхүүний чанар, үндэсний брэнд гаргах тал дээр илүү анхаарч байна¹⁴.

Нөлөөллийг бууруулах/Сайжруулах арга хэмжээ

Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ (ХӨОГ) – ний эдийн засгийн талаарх зүйл заалтууд

2009 онд зүүн өмнөд Монголын Оюу Толгой дахь зэс-алтны уурхайн барилгын ажил ба үйлдвэрлэлийг хамарсан Монгол улсын Засгийн газар, Айванхое Майнз Монголия Инк, Рио Тинто Интернейшнл Холдингс ХХК – ний хооронд байгуулагдсан Хөрөнгө оруулалтын гэрээ – нд гарын үсэг зурсан. Оюу Толгойн ХӨОГ нь Төслийн эдийн засагт оруулах хувь нэмрийг зохих ёсоор хэрэгжүүлж, зохицуулж байгаа болон үр дүнд нь гарах бүх ашиг тусыг нь хангалттай авч хуваарилж байх явдлыг баталгаажуулсан үндсэн механизм, баримт бичиг юм. Татварын журам ба санхүүгийн орчинтой холбоотой заалтуудыг Гэрээнд бас тэмдэглэсэн. **ХӨОГ нь Оюу Толгой Төслийн маш чухал баримт бичгүүдийн нэг бөгөөд Оюу Толгой – н бүх үйл ажиллагаанд хэрэглэгдэх болно.**

Монгол улсын 2006 оны Ашигт малтмалын хуулинд тодорхойлсон шаардлагын дагуу ХӨОГ – г хэрэгжүүлэх ба бүх урьдчилсан нөхцлийг биелүүлэх үед Монгол улсын Засгийн газар нь Оюу Толгойн 34% - ийн хувьцаа эзэмшигч болсон. ХӨОГ –г эхний 30 жилийн дараа амжилттай шинэчлэх үед Монгол улсын Засгийн газар нь харилцан тохиролцсоны үндсэн дээр өөрийн эзэмших хувьцааны хэмжээг 50% хүртэл нэмэгдүүлэх сонголттой байх болно.

ХӨОГ нь Төслийн эдийн засаг нийгмийн суурь нөхцөл тогтвортой байх хууль эрхзүйн үндэс суурь нь болж өгсөн бөгөөд ингэснээрээ төслийг улсын, бүс нутгийн болон орон нутгийн сайн сайханд тасралтгүй хувь нэмэр оруулах боломжийг хангаж байна. Өнөөдрийг хүртэлх хугацаанд ХӨОГ-нд сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлийн болон эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх хэд хэдэн хөтөлбөр ба схемүүдийг нэмж оруулаад байна. Эдгээр хөтөлбөр, санаачлагууд нь энэ Бүлгийн нөлөөллийг бууруулах хэсгүүдэд тодорхойлогдсон.

Улсын орлого зарцуулалтын ашиглалт ба ил тод байдал

¹² <http://www.mongolbank.mn/>

¹³ Дэлгэрэнгүйг Оюу Толгой Эдийн Засагт Нөлөөлөх Байдлын Үнэлгээнээс харна уу.

¹⁴ ‘Голланд өвчин’-өөс сэргийлэхийн тулд Монгол улс эдийн засгийн тэнцвэржүүлсэн өсөлтийг эрэлхийлж байна. Ю.Хумбер. 2011 оны 3 сарын 8. Эх сурвалж: <http://www.bloomberg.com/news/2011-03-08/mongolia-says-shifting-focus-to-balanced-growth-from-mining.html>

Монгол улсын эдийн засагт томоохон мөнгөний урсгал үүсч байгаа нь нилээд эерэг нөлөөлөл боловч Монгол улсын иргэд Оюу Толгойн төслийн ашиг тусыг хүртэх явдал нь Засгийн газрын эерэг өөрчлөлт үзүүлэх чадвараас хамаарна. Үүнд төсвийн орлого, зарлагыг хянах ба тайлагнахад Засгийн газрын хариуцлага ба ил тод байдал мөн түүнчлэн засгийн газрын бүх түвшинд хүлээн авсан хөрөнгийн ашиглалтыг зохих ёсоор төлөвлөх ба үр дүнтэй хэрэгжүүлэх чадвар зэрэг нь шийдвэрлэх ач холбогдолтой байх болно.

Үр дүнтэй удирдлага ба ил тод байдал нь байгалийн баялгаа ашиглан маш их гэнэтийн орлого олж буй бусад хөгжиж буй эдийн засагтай орнуудыг шаналгаж байгаа “баялгийн хараал”-аас зайлсхийхэд нэн чухал гэдгийг Оюу Толгой нь хүлээн зөвшөөрч байгаа юм.

2005 онд Монгол улсын Засгийн газар Олборлох салбарын ил тод байдлын санаачлага (ОСИТБС) – ыг хэрэгжүүлэх үүрэг авсан бөгөөд 2010 оны 10 – р сарын 19 – нд Монгол улс “ОСИТБС – д нэгдэн орсон улс” гэж тодорхойлогджээ. Монгол улсын талаарх ОСИТБС – ын тайлангуудыг дараах вэбсайтаас олж болно: <http://eitimongolia.mn/>.

Оюу Толгойн зүгээс Монгол улсын Засгийн газарт засгийн газрын янз бүрийн салбар хэлтсүүдийн хүлээн авсан татвар болон бусад төлбөрүүдийн талаарх мэдээллийг ил тод болгох ба тайлагнах замаар ОСИТБС ба Ил тод байдал ба хариуцлага (ИТБХ)¹⁵ – ын санаачлага зэрэг ил тод байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлсээр байх болно. Төсөл нь бүс нутгийн болон орон нутгийн хөгжлийг дэмжих ба удирдлагын чадавхийг бэхжүүлэх зорилгоор ТББ-ууд болон Олон улсын санхүүгийн байгууллагууд үүний дотор Олон улсын валютын сан (ОУВС) ба Дэлхийн банк зэрэгтэй уялдаа холбоотой ажиллах болно (*Хүснэгт 7-4 “Эдийн засгийн нөлөөлийн тойм”* – нд жагсаасан Оюу Толгой – н Хөрөнгө оруулалтын гэрээний 4.4.1, 4.4.6, 4.5 ба 4.13 – р зүйл – ийн дагуу).

Бүс нутгийн болон сумын түвшинд Оюу Толгойн өмнийн говийн нийлүүлэгчдийг хөгжүүлэх бодлого, *Орон нутгийн нийлүүлэгчийн хөгжлийн хөтөлбөр* ба *Орон нутгийн бизнес эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр* – зэрэг ажил эрхлэлт ба хангамжид олгосон давуу байдлаар дамжуулан Төслийн санхүүгийн ашиг тусыг хүртэх боломж сайжрах болно. Эдгээр хөтөлбөрүүдийн дэлгэрэнгүйг *Нөлөөлийн бүлэг С9: Хөдөлмөр эрхлэлт ба D17: Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө* – нд оруулсан байгаа. Төсөл нь бас орон нутгийн захиргааны байгууллагуудын орлогыг удирдах чадавхийг нь бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болно (илүү тодорхой мэдээллийг 7.4.3 – р хэсэг “Улсын төсөвт оруулах орлогын өсөлт” – ээс үзнэ үү).

Төслийн бүс нутаг ба сумын түвшин дэх санхүүгийн үр өгөөжийг дээшлүүлэх ажлууд нь *Монголын Тэргүүн Санаачлага, Орон нутгийн ханган нийлүүлэгчдийг хөгжүүлэх хөтөлбөр, Орон нутгийн бизнес, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр* зэргээр дамжуулан орон нутгийн ажил эрхлэлт, ханган нийлүүлэлтийг дэмжих байдлаар илрэнэ. Эдгээр хөтөлбөрүүдийн талаарх дэлгэрэнгүйг *Бүлэг С9: Ажил эрхлэлтийн нөлөөллийн үнэлгээ, Бүлэг D17: Ажиллах хүчний менежментийн төлөвлөгөө* зэрэг бүлгүүдээс харна уу. Мөн түүнчлэн төслийн зүгээс орон нутгийн удирдлагуудын төсвийн менежментийг чадавхижуулах талаар туслалцаа үзүүлэн ажилладаг (*Дэлгэрэнгүйг 7.4.3 “Улсын төсвийн орлогын өсөлт” хэсгээс харна уу*).

Оюу Толгой эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээнд тулгуурлан гаргасан бодлогын зөвлөмжүүд

Оюу Толгой төсөлд хийгдсэн Эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээнээс гарсан хамгийн чухал дүгнэлтүүдийн нэг нь валютын ханш чангарсантай холбоотойгоор уул уурхайн бус салбаруудын өрсөлдөх чадвар буурах эрсдэл бий гэж үзсэн. Үүнээс сэргийлэхийн тулд Монгол улс дараах бодлогын асуудлуудыг авч хэрэгжүүлэхийг судалгааны үр дүн санал болгосон. Үүнд:

- Бэлэн мөнгө иргэдэд тараахын оронд үндэсний баялаг хуримтлалын сан бий болгож, Оюу Толгой төслөөс орж ирэх мөнгийг хуримтлуулсны үндсэн дээр валютын ханш хэлбэлзэх,

¹⁵ ИТБХ – ын санаачлага нь ил тод байдал ба хариуцлагын оролцооны нөлөөлөл ба хэмжээ далайцыг өргөтгөх хандивлагчийн хамтарсан тогтолцоо юм. Тэр нь засгийн газар, компани болон бусад байгууллагуудын зүгээс илүү их шударга байдлыг дэмжихэд чиглэсэн өргөн хүрээний байгууллага ба төслийг нэгтгэдэг. Иймээс олон нийт тэднийг хариуцлагад татаж чадна. Хамтын ажиллагааг хувийн байгууллага, тэргүүлэх хоёр талт хандивлагч болон ТББ – уудыг багтаасан салбарт тэргүүлэх найман ивээн тэтгэгчдийн янз бүрийн бүлгүүд тэргүүлдэг. Уг санаачлагын сүүлийн үеийн нийтлэлд “*Байгалийн нөөцийн удирдлага. Ил тод байдал ба хариуцлагын шинэ хил хязгаар*” (С. Дарби, 2010). Эх сурвалж: www.transparency-initiative.org

буурах үед улсын эдийн засгийг дэмжих зорилгоор ашиглах. Мөн түүнчлэн цалин, тэтгэвэрийг шийдэх г.м

- Валютын ханшийн өөрчлөлтийг зөв удирдах, тэр дундаа худалдааны огцом өөрчлөлтөөс үүсэх эдийн засгийн үр дагаварыг шийдвэрлэх талаар уян хатан байх

Нөлөөллийн зэрэглэл

Оюу Толгой Төслийн барилгын ажлын ба үйлдвэрлэлийн шатнаас үүсэн гарч байгаа макро эдийн засгийн нөлөөлөл нь **урт хугацаагаар** үргэлжлэх төлөвтэй байна (≥ 27 уурхайн үргэлжлэх хугацаа). Урьдчилан таамагласан нөлөөллийн далайц нь үүсэх **гарцаагүй** магадлалтай **өргөн тархсан** байх болно. Монголын ард түмний Төслийн орлогын ашиг тусийг хүртэх хэмжээ нь Монгол улсын Засгийн газрын төсвийн орлогоо ухаалаг бөгөөд шудрага байдлаар хянах, удирдах ба зарцуулах чадвараас хамаарна.

Хэрэглээний бараа, бүтээгдэхүүний өсөлт, улсын эдийн засагт уул уурхайн салбарын давамгайлах байдал үүсэхтэй холбогдон төгрөгийн ханш, түүний валюттай харьцах ханш өсөх нь зарим нэг сөрөг үр дагавар авч ирэх магадлалтай. Уул уурхайн бус бусад салбарын хөгжил, тэднийг засгийн газрын бодлогоор дэмжилгүйгээр явах нь Монгол улсын эдийн засаг дан ганц уул уурхайн салбараас хамаарсан байдалд хүрэх аюултай. Засгийн газраас авч хэрэгжүүлэх эдийн засаг, санхүү, мөнгөний зөв бодлого нь "Голланд өвчин"-өөс сэргийлэх гол арга зам юм.

Үлдэх нөлөөллийн зэрэглэл нь дээр тодорхойлон бичсэн арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлнэ гэж төсөөлбөл **эерэг** байна гэж үзэж байна.

7.3.3 Үнийн инфляци ба амьжиргааны өртгийн өсөлт

Нөлөөллийн тодорхойлолт

Монгол улсын эдийн засаг нь *Бүлэг В1: Танилцуулга* – д тодорхойлсноор инфляцид автамтгай бөгөөд социализмын дараах үе 2008 – 2009 онд болсон дэлхийн нийтийн санхүүгийн хямралын үед үүссэн инфляцийн түвшин ¹⁶ 20%-аас ¹⁷ хэтэрч байсан. 2009 оноос эхэлсэн улс орны эдийн засгийн дахин сэргэлт нь инфляцийг аажмаар буурахад хүргэсэн бөгөөд 2010 онд (жилийн эцсийн өөрчлөлт) түүнийг 14% орчим байна гэж мэдээлж байхад дэлхийн дундаж инфляци (жилийн эцсийн өөрчлөлтийн утга) 5.5% ¹⁸ байсан байна (Зураг 7-3– г үзнэ үү).

¹⁶ Инфляцийн түвшин гэдэг нь барааны үнийг бараа худалдан авах стандарт чадвартай харьцуулахад өндөр байгааг тодорхойлох үзүүлэлт юм. Инфляцийн түвшиний нэг хэмжигдэхүүн нь хэрэглэгчийн үнийн индекс (ХҮИ) буюу ард иргэдийн өргөн хэрэглээний бараа болон үйлчилгээний үнэ юм.

¹⁷ Эх сурвалж URL: http://www.indexmundi.com/mongolia/inflation_rate_consumer_prices.html

¹⁸ Эдийн засгийн ажиглалт. Монголын инфляцийн статистик (оны эцсийн өөрчлөлт %). Эх сурвалж URL: http://www.economywatch.com/economic-statistics/Mongolia/Inflation_End_of_Year_Change_Percentage

Зураг 7-3: Монгол улсын инфляцийн динамик, 2008-2011



Эх сурвалж: Худалдааны эдийн засаг¹⁹

2011 оны эхээр ОУВС Монголд эдийн засгийн хүчтэй сэргэлтийн суурин дээр инфляци хэдийнээ “хэтэрхий өндөр” байсан²⁰ гэж мэдээлж байсан.

Түүнээс гадна Монголчуудын гурвны нэг нь амьжиргааны доод түвшнээс доогуур амьдарч байгаа бөгөөд 2008 – 2009 оны эдийн засгийн хямрал болон 2010 оны хатуу өвлийн нөлөөлөл бүрэн арилаагүй байгаатай хослон түүнийг зохих ёсоор бууруулахгүй бол улс орны хүн ам эдийн засгийн өөрчлөлтөнд эмзэг хэвээр үлдэнэ.

ОУВС²¹ нь мөн цаашлаад 2011 онд төлөвлөсөн Монгол улсын төсвийн зарлагын ихээхэн өсөлт нь ялангуяа инфляци ба валютын ханшийн илүү хурдан өсөлтөөр дамжуулан улс орны эдийн засагт гарз хохирол учруулсан байж магадгүй гэж урьдчилан таамаглаж байна (нөлөөллийн өмнөх хэсэгт “Валютын ханшийн өсөлт” – ийг бас үзнэ үү). Энэ нь өрхийн худалдан авах чадварыг бодитоор бууруулахад хүргэж болно. Ядуу хүн амд өөрсдийн хязгаарлагдмал орлогод учрах нөлөөллийг сөрөх санхүүгийн хүчтэй уян хатан чанар байдаггүй болохоор ялангуяа гол хүнсний бүтээгдэхүүнд өндөр инфляци илэрхэд тэдэнд хамгийн ихээр нөлөөлдөг.

Ханбогд сумын хүрээнд орон нутгийн үнэ ба амьжиргааны өртөг ерөнхийдөө ОТ – н барилгын ажлын үе шатны эхэнд өсөх төлөвтэй байна. Хэдийгээр хэрэглээний үнийн өсөлт нь Монгол улсын бүх бүс нутагт бүртгэгдсэн ч гэсэн сумын түвшинд орон нутгийн хэрэглэгчийн үнийн өсөлт бий болж байгааг харуулах мэдээлэл байхгүй байна²². Амьжиргааны өртгийн өсөлт ба үнийн инфляцийн гол шалтгаан нь дараах байдалтай байх шинжтэй байна:

- Оюу Толгойн үйл ажиллагаа ба энэ бус нутаг дахь бусад хөгжлийн төсөлтэй холбоотой орон нутгийн зарлагын өсөлт;
- Амин зуулгаас цалинтай ажилд шилжсэн шилжилтийн тусламжтайгаар орон нутгийн хүн амын зарцуулалтын чадварт өсөлт гарсан.
- Хүн амын хадгаламж ба зээлд өргөнөөр хамрагдах боломж нэмэгдсэнтэй хослон

¹⁹ <http://www.tradingeconomics.com/mongolia/inflation-cpi>

²⁰ Олон улсын валютын сан. Монгол улс— 2011 оны зорилгын 4 – р бүлгийн урьдчилсан дүгнэлт. 2011 оны 2 – р сарын 17. Эх сурвалж URL: <http://www.imf.org/external/np/ms/2011/021711.htm>

²¹ Мөн тэнд

²² Монголын үндсэний хэрэглэгчийн үнийн индекс, 2011 оны 6 – р сар.

Энэ нутагт хэрэгжсэн ОТ ба бусад төслөөс үүдсэн орон нутгийн зарлагын өсөлт нь бүс нутагт болон орон нутагт хэрэглэж болох янз бүрийн бараа үйлчилгээнд зарцуулах зарцуулалтаас үүдэх болно, үүнд:

- Уурхайн барилга ба үйлдвэрлэл болон туслах байгууламжтай холбоотой хангамж;
- Ачаа тээвэрлэлт болон агуулахын үйлчилгээ;
- Хүнсний бүтээгдэхүүний хангамж, нийтийн хоол ба цэвэрлэгээний үйлчилгээ;
- Барилга ба туслах материал болон дагалдах хэрэгслэлүүд;
- Техникийн үйлчилгээ;
- Байр, угаалгын газар ба хувцасны хангамж;
- Жижиглэн худалдааны үйлчилгээ;
- Түлшний хангамж;
- Хувийн эмнэлгийн үйлчилгээ; ба
- Амралт, зугаа цэнгэл.

Орон нутгийн бизнесийг өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг хангахуйц чадвартай болж хөгжих хүртэл томоохон хэмжээний төслүүдийн хооронд явагдах хангалттай бус бараа материал ба үйлчилгээний төлөөх өрсөлдөөн нь орон нутгийн түвшинд үнийг өсгөхөд хүргэх болно. Энэ хандлагыг сум руу хүн ам бөөнөөрөө нүүн шилжиж ирснээс үүдэх бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний өсөн нэмэгдсэн эрэлт хэрэгцээ нь улам хурдасгах болно. Түүнээс гадна буурай хөгжилтэй орон нутгийн зах зээл нь өндөр орлоготой хүн амын тоо өсөхөд /гол төлөв уул уурхайн салбарын ажилчид ба гадаадын боловсон хүчин/ инфляцийн өсөлтөөр хариу барих төлөвтэй байгаа. Энэхүү нөлөөлөл нь орон сууц, хүнсний бүтээгдэхүүн, зоогийн газар, тээврийн үйлчилгээ, эмнэлгийн үйлчилгээ, амралт болон бусад төрлийн зүйлсийн үнийн өсөлтийг шингээх чадвартай өндөр худалдан авах чадвар бүхий олон тооны хүн байгаагаас үүдэн бий болно.

Дээш чиглэсэн үнэ нь дараагаар нь амьжиргааны ерөнхий өртөгт, өөрөөр хэлбэл хэрэглээний үнэ, түрээс, хүнсний бүтээгдэхүүн, тээвэр болон ахуй үйлчилгээнд нөлөөлдөг бөгөөд инфляцитай шууд хамааралтай байдаг. Одоо хэрэгжиж байгаа буюу төлөвлөгдөж байгаа Оюу Толгой болон бусад томоохон төслүүдтэй холбоотойгоор амьжиргааны өртөг орон нутгийн түвшинд ба илүү өргөн бүс нутгийн түвшинд өсөх төлөвтэй байгаа (*Бүлэг С13: Хуримтлагдах нөлөөлөл – г бас үзнэ үү*).

Өсөн нэмэгдсэн амьжиргааны өртөг ба ерөнхий үнийн өсөлтийн нөлөөлөл нь орон нутгийн ард иргэдийн дунд янз бүрээр мэдрэгдэх болно. 2011 оны 6 – р сарын байдлаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээс Ханбогд сумын 15 гэр бүлийн 73 хүнийг эмзэг давхаргынх гэж тодорхойлсон.²³ Тогтмол орлоготой хүмүүсийн хувьд /төрийн албан хаагчид/ бас инфляцийн нөлөөллийг шингээхэд хүндрэл учирдаг. Барилгын шаттай харьцуулахад үйлдвэрлэлийн шатанд ажиллах хүчний эрэл хэрэгцээ буурдаг, зарим эдийн засгийн зарим шилжин ирэгчид өөр тийшээ нүүж одох болон ба орон нутгийн бизнесийн бүтээмж сайжирсан зэргийг тооцон үзэхэд үнэ тогтворжих хандлагатай байна.

Нөлөөллийг бууруулах/Сайжруулах арга хэмжээ

Төслийн нөлөөллийн бүсэд байгаа орон нутгийн ард иргэд болон ялангуяа эмзэг бөгөөд ядуу давхаргын хүн ам Төслийн инфляцийн нөлөөлөлд хамгийн ихээр нэрвэгдэх болно. Үнийн өсөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах ба сумын эмзэг давхаргын хүмүүсийг хамгаалах дараах үндсэн арга хэмжээнүүдийг авах болно:

- *Төслийн ажил эрхлэлтэд* орон нутгийн хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэх, ингэснээр хүн амын илүү их хувийг тогтвортой орлоготой болгох мөн тэдний инфляци болон амьжиргааны өртгийн өсөлтийг даван туулах чадавхийг бэхжүүлэх боломж олгоно (Хөрөнгө оруулалтын гэрээний 8.5.1 ба 8.5.2 – р зүйлийн дагуу барилгын ажлын үе шатанд Төслийн ажиллах хүчний наад зах нь 60% нь мөн уул уурхайн болон уул уурхайтай холбоотой ажлын 75 – аас багагүй хувь нь Монгол улсын иргэд байх болно);

²³ Ханбогд сумын Хөдөлмөр, нийгэм хангамжийн газрын статистик мэдээ, 2011, ОНХТХХ –ийн мэдээлсэнээр.

- Зорилтот бүлгүүдэд чиглэсэн хөрөнгө оруулалтаар рон нутгийн эмзэг болон ядуу гэр бүлийг шууд дэмжлэгээр хангах; Оюу Толгойд сумын эмзэг бүлгийг дэмжихэд зориулсан шууд дэмжлэгийн хөтөлбөр байдаг;
- Орон нутгийн ард иргэдийн ажил эрхлэх чадварыг нэмэгдүүлэх ба тэдний урт хугацаагаар Төслөөс хамааралтай байх хамааралыг бууруулахын тулд *мэргэжлийн ур чадварын сургалт ба боловсролын хөтөлбөрт* хамруулах;
- Өмнийн говийн нийлүүлэгчдийг хөгжүүлэх бодлого ба *Орон нутгийн бизнес эдийн засгийн хөгжил* (ОНБЭЗХ) – ийн хөтөлбөрөөр дамжуулан *орон нутгийн бизнесийн хөгжилд* түлхэц үзүүлэх; ба
- Орон нутгийн ард иргэдийн эдийн засгийн өөрчлөлтөнд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхийн тулд орлого нэмэгдүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

Оюу Толгой төсөл нь бас Ханбогд суманд ХҮИ ба гол бүтээгдэхүүний үнийг хянаж байх болно. Энэ арга хэмжээ нь үнийн динамик ба амьжиргааны өртгийг мөрдөх боломж олгох боловч Төслөөс үүссэн инфляцийг бусад шалтгаанаар үүссэн инфляцийн үр нөлөөнөөс шууд тусгаарлах нь асуудал үүсгэж болзошгүй. Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь иргэдийн өдөр тутмын хэрэглээ болох хүнс, байр сууц, бензин, хувцас, унаа, харилцаа холбоо, эрүүл мэндийн үйлчилгээ зэргийн үнэ хугацааны туршид хэрхэн өөрчлөгдөж, өсч буйг хэмждэг түгээмэл хэрэглэгддэг үзүүлэлт юм. Хэрэглээний үнийн индекс нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний өссөн буюу буурсан шалтгааныг гаргаж ирдэггүй боловч тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ханш цаг хугацааны туршид хэрхэн өөрчлөгдөж байсныг ажиглаж, гаргах боломж бүрдүүлдэг.

Инфляци нь хүн амын худалдан авах чадварыг бууруулдаг бөгөөд үүний үр дүнд олон төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг орлогын түвшин болон амьжиргааны өртөг өссөн зөрүүнээс үүдэн авах яадвар нь мууддаг байна. Иймээс Оюу Толгой төслийн зүгээс эхний ээлжинд авч хэрэгжүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь орон нутгаас ажилчид сонгох болон Төслийн ойролцоох сумдууд болон Өмнөговь аймагт ажлын байр болгох зэргээр тогтмол дэмжлэг үзүүлэх юм. Орон нутагтын иргэдэд тогтмол ажлын байр (шууд болон шууд бус ажлын байр) бий болгох нь орлогын тогтмол эх үүсвэртэй болохыг хангах ба улмаар эдийн засгийн савалгаанаас хамгаалахад дэмжлэг болно. Орон нутгийн иргэдийн инфляцитай тэмцэх тал дээр Оюу Толгой төслөөс өөрийн ажилчдын дунд жил тутмын цалингийн судалгааг хийж байгаа ба уг судалгаагаар инфляцын болон нэмэгдэж буй амьжиргааны өртгийн эсрэг ажилчдын цалинг тохируулан нэмэх ба салбарын цалингийн “бенчмарк”-д тохируулна. .

Давуу эрхээр орон нутгаас ажилтан элсүүлэх, уул уурхайн ажиллах хүчний сургалт, хөдөлмөрийн хөлс, орон нутгийн ажилчдын сургалт мөн түүнчлэн цомхотгох, халах зэрэг Төслийн бууруулах арга хэмжээний тухай илүү тодорхой мэдээллийг *Бүлэг D17: Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө* – нд оруулсан болно. Малчид болон эмзэг давхрагын хүмүүст зориулсан тусламжийн төрлийг *Бүлэг D15: Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө* – нд тодорхойлсон байгаа. *Үндэсний нийлүүлэгчдийг хөгжүүлэх бодлого, Орон нутгийн нийлүүлэгчдийг хөгжүүлэх бодлого болон Орон нутгийн эдийн засаг ба бизнес хөгжлийн хөтөлбөрүүд зэрэг шууд бус болон орон нутгийн бизнес боломжуудыг дэмжих арга хэмжээнүүдийн талаар Бүлэг C9: Хөдөлмөр эрхлэлт* – д илүү дэлгэрэнгүй авч үзсэн. Ханбогд сум ба Өмнөговь аймагт эдийн засгийн өсөлт хөгжилтийг удирдах ба нөлөөллийг бууруулах арга хэмжээг *Бүлэг D16: Хүн амын төвлөрлийн менежментийн төлөвлөгөө* – нд оруулсан болно.

Нөлөөллийн зэрэглэл

Нөлөөлөл бууруулах арга хэмжээ аваагүй тохиолдолд үнийн өсөлт ба амьжиргааны өртгийн өсөлттэй холбоотой инфляцийн нөлөөлөл нь **урт хугацааных** байх ба Төслийн үйлдвэрлэлийн хугацааны туршид үргэлжилнэ гэж урьдчилан таамагласан бөгөөд уурхайн хаалтын үйл ажиллагааны таамаглалд үндэслэн дифляцийн нөлөөлөлд хүргэх болно. Инфляцийн нөлөөллийн цар хэмжээг **өргөн тархсан** байх бөгөөд тохиолдох **магадлалтай** гэж урьдчилан таамагласан байна. Энэ нөлөөлөл нь дээр тодорхойлсон бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн ч гэсэн ялангуяа эмзэг болон ядуу өрхүүдэд онцгой нөлөөлөл үзүүлэх болно. Үлдэгдэл нөлөөллийн (бууруулах арга хэмжээний дараа) зэрэглэл нь **дунд зэрэг сөрөг** байх төлөвтэй байна.

7.3.4 Улсын төсөвт оруулах орлогын өсөлт

Нөлөөллийн тодорхойлолт

Олборлох салбар бол хуулиар ногдуулсан татвар, хураамж болон бусад албан ёсны төлбөрийн хэлбэрээр төсвийн орлогын гол эх үүсвэр болдог. Хууль хүчин төгөлдөр болсон сүүлийн гурван жилийн туршид 2006 – 2009 онд алт ба зэсэнд ноогдуулсан 68% - ийн Гэнэтийн ашгийн татвар (ГАТ)²⁴ – ын мэдээгээр 968 тэрбум төгрөгийг Монгол улсын хөгжлийн санд оруулсан нь нийгэм ба дэд бүтцийн хөгжилд²⁵ хэрэглэгдэх нилээд их хэмжээний хөрөнгө нөөцийг бүрдүүлэх боломж олгосон байна. Дараа нь гадаадын хөрөнгө оруулалтад илүү таатай уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор 2011 оны 1 – р сард Гэнэтийн ашгийн татварыг хүчингүй болгосон.

Хүчингүй болгосон Гэнэтийн ашгийн татварыг нөхөхийн тулд Засгийн газар нь эрдэс баялагийн салбарын нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлсэн. 2010 оны 11 – р сарын 25 – ны өдөр Улсын их хурал (Монголын парламент) Ашигт малтмалын тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтийг баталсан. Тэр нь 2011 оны 1 сараас хэрэглэгдэх нөөц ашигласны шинэ нэмэлт татварыг оруулсан. Нөөц ашигласны нэмэлт татварын хэмжээ нь ашигт малтмалын төрөл ба тэдний зах зээлийн үнээс хамааран өөрчлөгддөг бөгөөд бусад ашигт малтмалыг бодвол зэсэнд нилээд өндөр байдаг; зэсийн хувьд нөөц ашигласны нэмэлт татварын хэмжээ хүдэрт 22% ба 30% - ийн хооронд, баяжмалд 11% ба 15% - ийн хооронд ба эцсийн бүтээгдэхүүнд 1% ба 5% - ийн хооронд байна. Хэрвээ зэсийн үнэ тонн нь 5,000 ам.доллараас доош²⁶ буувал нөөц ашигласны нэмэлт татвар төлөгдөхгүй.

Доорхи хүснэгт нь нэг тонн зэсийн үнэ 9000 ам.доллартай тэнцүү байх үед зэсийн ордын төслийн жишээн дээр хоёр үе шаттай нөөц ашигласны төлбөрийн шинэ горимын нөлөөллийг дүрсэлж байна.

Хүснэгт 7-3: 9000 ам.доллар/тонн-ын зах зээлийн үнэтэй зэсийн ордын төслийн нөөц ашигласны төлбөрийн судалгаа

	Бараа бүтээгдэхүүн	Нөөц ашигласны төлбөрийн шинэ тариф	Шинэ журмын дагуух нөөц ашигласны төлбөр(ам.доллар/тонн)
1	Зэсийн хүдэр	35% (5% - ийн стандарт хэмжээн дээр нэмээд 30% - ийн нэмэлт татвар)	3150,00 ам.доллар
2	Зэсийн баяжмал	20% (5% - ийн стандарт хэмжээн дээр нэмээд 15% - ийн нэмэлт татвар)	1800,00 ам.доллар
3	Зэсийн бүтээгдэхүүн	10% (5% - ийн стандарт хэмжээн дээр нэмээд 5% - ийн нэмэлт татвар)	900,00 ам.доллар

Эх сурвалж: Хоган Ловелс²⁷

Монгол улсын Сангийн яам нөөц ашигласны төлбөрийн шаталсан төлбөр нь жилд улсын төсөвт 95 тэрбум төгрөг оруулна гэж тооцож байна²⁸. 2008 онд уул уурхайн салбараас олсон татварын орлого нь улсын төсвийн орлогын 43% – ийг, ДНБ – ний 15% -ийг бүрдүүлж байна.

²⁴ ГАТ нь зэс ба алтны дээд зэргийн өндөр үнээс улсад ашиг гаргах боломж олгохын тулд боловсруулагдсан болно. Гэнэтийн ашгийн татварын хууль тонн нь 2600 доллараас дээш худалдагдсан зэс ба нэг унци алтны 500 ам.доллараас дээш үнэд 68% - ийн татварыг үнэлж тогтоосон байна. 2008 оны дундуур дэлхийн үнэ унасны дараа ГАТ – ын босго алтанд нэг унцид 500 ам.доллараас 850 ам.доллар хүрч өссөн байна. Гэнэтийн ашгийн татвараас олсон орлого холбогдох хуулийн дагуу тусгай санд ордог.

²⁵ “Гэнэтийн ашгийн татвар бараг 1 их наяд төгрөг бий болгосон байна” гэж 2009 оны 8 – р сарын 21 – нд Бизнес Монголиа-д мэдээлжээ. Эх сурвалж URL: <http://www.business-mongolia.com/mongolia/2009/08/21/windfall-profit-tax-generated-nearly-1-trillion-mnt/>

²⁶ Монголиа Алерт – Ашигт малтмал ашигласны төлбөрийн шинэ журам: Хоёр үе шаттай ашигт малтмал ашигласны төлбөрийн хэмжээ. 2011 оны 1 – р сар <http://ehoganlovells.com/ve/61VLt636179wwO0/VT=1>

²⁷ Мөн тэнд.

Монголын зэсийн болон алтны гол ордыг хөгжүүлэгчийн хувьд Оюу Толгой нь нөөц ашигласны төлбөр болон бусад хэд хэдэн төрлийн татварыг заавал төлөх ёстой. Төслөөс улсын төсөвт оруулсан гол орлого нь дараах төрлийн төлбөрүүдээс бүрдэнэ:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;
- Ашигт малтмал ашигласны төлбөр, захиргааны хураамж, түрээс ба түрээсийн төлбөр;
- Монгол улсын нутаг дэвсгэр дээр худалдаж борлуулсан бараа үйлчилгээний Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ);
- Гаалийн татвар ба акцизын татвар;
- Бензин, дизель түлшний татвар;
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр борлуулалтын үнийн 5% - иар;
- Усны нөөц ашигласны ба газрын түрээсийн төлбөр;
- Ашигт малтмалын хайгуулын лиценз ба олборлолтын лицензийн төлбөр; ба
- Үл хөдлөх хөрөнгийн татвар.

Оюу Толгойн 2000 – аас 2010 оны хоорондох татварын тайлангаас үзэхэд Оюу Толгой нь Монгол улсын Засгийн газрын төсөвт үүний дотор улс, аймаг, сумын төсөвт нийт 62,8 тэрбум төгрөг төлсөн байна.

Барилгын ажлын ба үйлдвэрлэлийн шатанд бүс нутаг (аймаг) ба орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад оруулсан орлого нь бас янз бүрийн татвар хураамжаас бүрдэнэ. Олборлож борлуулсан бүх ашигт малтмалын борлуулалтын үнийн дүнгээс орон нутгийн засаг захиргаанд нөөц ашигласны төлбөрийг төлөх үйлдвэрлэлийн шатны үед орлогын гол өсөлт гарах болно²⁹. 2013 оны эхээр арилжааны үйлдвэрлэл эхэлсэн үеэс эхлэн Оюу Толгой нь Монгол улсын Засгийн газарт нөөц ашигласны төлбөр төлж эхлэх бөгөөд нөөц ашигласны төлбөр нь дунджаар Оюу Толгойн төлөх татварын ойролцоогоор 70-80% - ийг бүрдүүлэх болно. Хуулинд заасны дагуу нөөц ашигласны төлбөрийн 70% улсын төв төсөвт үлдэх ба харин 20% ба 10% - ийг нь тус бүр аймаг ба сумын төсөвт шилжүүлэх ёстой.

Орон нутгийн түвшинд Оюу Толгой төслөөс төлсөн татварын орлого нь шууд Ханбогд сумын төсөвт орох бөгөөд тодорхой хувийг нь аймгийн захиргаанд шилжүүлнэ. Оюу Толгой Төслийн Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээнд зааснаар (2009 оны 9 – р сар) дараах орлогуудыг орон нутгийн төсөвт төлөх ёстой:

- Хувь хүний орлогын албан татвар;
- Газар ашиглалтын төлбөр;
- Үл хөдлөх хөрөнгийн татвар;
- Тэмдэгтийн хураамж;
- Ус ашигласны төлбөр; ба
- Авто тээврийн хэрэгслийн татвар.

²⁸ Гэнэтийн ашгийн татварыг орлуулах нөөц ашигласны төлбөрийн шаталсан хэмжээ. Эх сурвалж: Монголын уул уурхай сэтгүүл, 2010 оны 4 – р сар. Мэдээлсэн: Монгол улсын Бизнесийн зөвлөл – д

http://www.bcmongolia.org/index.php?option=com_content&view=article&id=394:graduated-royalty-rates-to-replace-windfall-profits-tax&catid=44:mongolia-business-news&Itemid=103


²⁹ Ашигт малтмалын тухай хуулийн дагуу стандарт уурхайн ашигласны төлбөрийг горим уул луурхайн лиценз эзэмшигч олборлосон ашигт малтмалын нийт борлуулалтын үнэд үндэслэн тогтоосон стандарт уурхайн ашигласны төлбөр төлнө гэдэг нөхцөл тавьсан. Одоогийн стандарт уурхайн ашигласны төлбөрийн хэмжээ Монгол улсад борлуулсан нүүрсний хувьд мөн түүнчлэн Монголд борлуулсан нийтлэг тохиолддог ашигт малтмалын хувьд 2,5% байх ба бусад бүх ашигт малтмалын хувьд 5,0% байна (ө.х. гадаадад борлуулсан нүүрс, гадаадад борлуулсан нийтлэг тохиолддог ашигт малтмал ба Монголд болон гадаадад борлуулсан нийтлэг бус тохиолддог ашигт малтмал). Эх сурвалж: Хоган Ловелс, Монголиа Алерт – Ашигт малтмал ашигласны төлбөрийн шинэ журам: Хоёр үе шаттай ашигт малтмал ашигласны төлбөрийн хэмжээ (2011 оны 1 – р сар). <http://ehoganlovells.com/ve/61VLt636179wwO0/VT=1>

Оюу Толгойн бодит зарцуулалтын мэдээгээр 2002 оны эхнээс 2010 оны хооронд Оюу Толгойн бүс нутагт зарцуулсан ойролцоогоор 23,9 сая ам.долларын нийт шууд зарцуулалтын бараг 60%-г нь ³⁰ орон нутгийн ба аймагт төлсөн татвар эзэлж байна. 2001-2010 оны хооронд Оюу Толгойгоос Өмнөговь аймгийн Ханбогд, Даланзадгад ба бусад сумын захиргаанд төлсөн нийт төлбөр нь ойролцоогоор 14 сая ам.доллар болж байна. Эдгээр төлбөрийн 80 орчим хувь буюу 11 сая ам.доллар нь ашигт малтмалын хайгуулын ба лицензийн төлбөр байсан бөгөөд Монгол улсын Засгийн газарт төлсөн нийт төлбөрийн дүн 52 сая ам. долларт хүрсэн байна. (Зураг 7-4-г үзгэ үү.)

2010 онд Оюу Толгой нь 1,9 орчим сая ам.доллар (ойролцоогоор 3,3 тэрбум төгрөг) – ийг Өмнөговь аймагт төлсөн, үүний 70%-г нь хувь хүний орлогын албан татварт, 24%-г нь усны төлбөр, газрын хураамж, нийтлэг тохиолддог ашигт малтмал ба зам ашигласны төлбөрт Ханбогд сумын захиргаанд төлсөн. 3,3 тэрбум төгрөгөөс 1,3 тэрбум орчим төгрөг нь Ханбогд сумын төсөвт татвар ба татварын бус орлогын хэлбэрээр төлөгдсөн байна. Ханбогд суманд төлсөн Оюу Толгойн төлбөрт бас 631,8 сая төгрөгийн (52%) гадаадын ажиллах хүч ашигласны төлбөр, 333,5 сая төгрөгийн (28%) газрын хураамж, 226 сая төгрөгийн (19%) нийтлэг тохиолддог ашигт малтмал ашигласны төлбөр ба 11,9 сая төгрөгийн усны хураамж орсон.

Өмнөговь аймаг татварын орлогынхоо нилээд хувийг төв засгийн газрын улсын төсөвт шилжүүлдэг бөгөөд дараа нь уг хөрөнгийг бусад аймгуудад дахин хуваарилдаг байна.

Зураг 7-4: Оюу Толгойн нийт татварын төлбөр, 2000-2010*



Эх сурвалж: Оюу Толгой, 2011. (UMG – Өмнөговь, UB – Улаанбаатар)

*Тайлбар: 2008 оныг хүртэл Монгол улсад төлсөн татварын орлогын хамгийн их хувийг нь Хайгуулын ба лицензийн төлбөр бүрдүүлж байна; орон нутгийн татварын орлого хайгуулын болон лицензийн хураамжийн хувийг бүрдүүлдэг гэж үзэж байна (төв засгийн газар орон нутгийн төсөвт хувь тэнцүүлсэн хувийг хуваарилдаг гэж үзээд).

2009 онд Оюу Толгойн орон нутагт төлсөн татварын хэмжээ 513'000 ам.доллар болж байсан нь аймгийн төсвийн ойролцоогоор 5% - ийг бүрдүүлсэн байна. 2010 онд Оюу Толгойн орон нутагт төлсөн татварын хэмжээ дөрөв дахин нэмэгдэж 2,3 сая ам.долларт хүрсэн бөгөөд энэ нь аймгийн төсвийн 27% байсан.

Өмнөговь аймаг нь Оюу Толгойгоос Монголын Засгийн газарт төлдөг нийт нөөц ашигласны төлбөрийн 33% - ийг авах эрхтэй гэдэгт үндэслэн 2013-2023 оны хооронд энэ аймаг 479 сая ам.доллар төлөгдөхөөр хүлээгдэж байгаа бөгөөд энэ хугацаанд төв засгийн газар уурхай ашигласны төлбөрт 1,1 тэрбум ам.доллар хүлээж авах болно (энэ тооцоо нь баримжаалсан тооцоо болно). Өмнөговь аймагт төлөх Оюу Толгойн татварын төлбөр нь энэ хугацаанд Монгол улсын Засгийн газарт төлөх нийт татварын төлбөрийн дунджаар 15 орчим хувийг бүрдүүлэх болно. Нөөц ашигласны төлбөрийн татварыг Төслийн Нөлөөллийн бүсийн дотор байгаа аймаг ба сумын

³⁰ Үүнд дэд бүтэц, орон нутгийн хангамж, сургалт ба чадавхийг бэхжүүлэлт, ажил эрхлэлт, татвар ба хандивын зарцуулалт.

захиргаанд зохих ёсоор шилжүүлсэн нөхцөлд нөөц ашигласны төлбөрийн татварын орлого орон нутгийн төсвийн орлогод ихээхэн хэмжээгээр нөлөөлөх болно.

Ерөнхийдөө зохих ёсоор удирдаж зохицуулсан үед татварын баазын өргөтгөл ба орон нутаг (Ханбогд сум) ба бүс нутаг (Өмнөговь аймаг) – ийн захиргааны байгууллагын хувьд их хэмжээгээр нэмэгдсэн орлого нь төсвийг нэмэгдүүлэх замаар орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг шийдвэрлэхэд туслах бөгөөд “улсын зарлагыг нэмэгдүүлэх ба орон нутгийн нийтийн үйлчилгээг сайжруулах боломжийг хангах ба тэр нь эргээд бизнесийг бэхжүүлэх ба амьжиргааны түвшинг сайжруулахад туслах болно.

Нөлөөллийг бууруулах/Сайжруулах арга хэмжээ

Татварын баталгаат орлогыг анхлан зориулахаар төлөвлөж байсан бүс нутгийн болон орон нутгийн зорилтот хөгжлийг санхүүжүүлэхэд тууштай, ил тодоор зарцуулбал татвар ноогдуулах үйл ажиллагаа нь бүс нутгийн болон орон нутгийн түвшинд хамгийн сайнаар нөлөөлж болдог.

Оюу Толгой төслөөс үүссэн улсын орлогод орсон ашиг ба орлогыг орон нутгийн ард иргэдэд мэдэгдэхүйц бодит ашигт шилжүүлсэн гэдэг баталгаа өгөхөд захиргааны зүгээс хуримтлагдсан хөрөнгийг үр дүнтэй төсөвлөх ба ухаалаг хуваарилах явдал нь хамгийн чухал хэвээр үлдэнэ. Гэвч одоо үед боловсон хүчин дутагдалтай, өмнө нь ийм их хэмжээний хөрөнгийн урсгал хангалттай биш байсан бөгөөд практик сургалт шаардлагатай байгаагийн улмаас орон нутгийн захиргааны байгууллагын томоохон хэмжээний төсвийг удирдах чадвар нь хязгаарлагдмал байна.

Оюу Толгой нь Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу өөрийн үүргээ биелүүлэхдээ ил тод байдлын өндөр стандартыг хангахын тулд мөн орон нутгийн захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр үүний дотор төсвийн удирдлага ба тайлагнал, төслийн удирдлага г.м. сургалтуудыг зохион байгуулах тал дээр Монгол улсын Засгийн газартай хамтран ажиллах болно. Энэ сургалтын нэг хэсэг нь сайн засаглал ба хөрөнгийн ил тод хуваарилалтын тухай мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдэх болно.

Ил тод байдлын үүднээс ОСИТБС – ын дагуу Монгол улсын хүлээх үүргийн хэрэгжилт үүний дотор Төслөөс хуулинд заагдсаны дагуу улсын төсөвт оруулсан төлбөр (орлого, уурхай ашигласны төлбөр, татвар, хураамж) – ийн тухай Засгийн газрын тайлагнал зэрэг нь хариуцлагыг хангах үндсэн хэрэгсэл болно. ОСИТБС нь бас компаниас засгийн газарт төлсөн бүх материаллаг төлбөрийг засгийн газрын хүлээж авсан бүх материаллаг орлоготой хамт олон нийтийн өмнө нээлттэй хялбар дөхөм, дэлгэрэнгүй бөгөөд ойлгогдохуйц байдлаар тогтмол хэвлэн нийтэлж байхыг шаарддаг. Энэ шаардлага нь орлогын урсгал ба түүнтэй холбоотой ашгийн талаарх нээлттэй байдлын нэмэлт баталгаа болно.³¹

Чадавхийг бэхжүүлэх үүднээс Оюу Толгой нь Засгийн газраас байгуулсан Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл (ӨГБХЗ) –тэй өөрийн үйл ажиллагаагаа зохицуулахын тулд Орон нутгийн бүсийн төлөвлөлт ба дэд бүтэц (ОНБТДБ) – ийн хэлтсийг байгуулж байна. ОНБТДБ – ийн гол зорилго нь Төслийн нутаг дэвсгэрийн хүрээнд бүс нутгийн тэнцвэржсэн тогтвортой төлөвлөлт ба холбогдох нийтийн дэд бүтцийг хангахад оршино. ОНБТДБ – ийн хөтөлбөрийг *Бүлэг В8: Хүн ам ба хүн амын шилжилт хөдөлгөөн*–д дэлгэрэнгүй авч үзсэн. ӨГБХЗ – ийн үйл ажиллагаа болон бусад орон нутгийн хамтын ажиллагааны санаачлагуудад оролцсоноор Оюу Толгой нь орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай дараах чиглэлүүдээр нягт хамтран ажиллах болно:

- Төрийн үйлчилгээний төлөвлөлтийг сайжруулах;
- Хүлээлтийг удирдан зохицуулж, ил тод байдлыг сайжруулахын тулд орон нутгийн ард иргэдтэй сайн харилцаатай байх; ба
- Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлснээр үйлдвэрлэлийн үе шатны туршид төрийн үйлчилгээнд орж ирэхээр хүлээгдэж байгаа ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг Төслийн үргэлжлэх хугацаа дууссаны дараа орон нутгийн хүн ардыг дэмжих боломжтой байхын тулд зөвөөр удирдан зарцуулах

Нөлөөлийн зэрэглэл

Улсын төсөвт оруулах орлогын өсөлтийн үзүүлэх нөлөөлөл нь **өргөн тархсан, гарцаагүй** тохиолдох магадлалтай, **дунд хугацааных** байна. Нөлөөллийн ерөнхий илрэх байдал нь эерэг

³¹ ОСИТБС – ын шалгуур үзүүлэлт. Эх сурвалж: eiti.org/eiti/principles

байх болно. Дээр тодорхойлсон бууруулах арга хэмжээнүүдийг зохих ёсоор хэрэгжүүлэх нь энэ эерэг нөлөөлөл нь урт хугацаанд тогтвортой байна гэдэг баталгаа өгөхөд чухал ач холбогдолтой байх юм.

7.4 ҮЛДЭГДЭЛ НӨЛӨӨЛЛИЙН ТОЙМ

Оюу Толгой төслийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараах нийгэм эдийн засгийн үлдэгдэл нөлөөлөлд дараах нөлөөллүүд багтана. Үүнд:

- Макро эдийн засгийн нөлөөлөл, тэр дундаа төслөөс улсын, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд үзүүлэх эдийн засгийн эерэг ашиг тус; ба төгрөгийн ханш чангарснаас уул уурхайн бус бусад салбарын өрсөлдөх чадвар буурах сөрөг нөлөөлөл
- Үнийн инфляци ба амьжиргааны өртгийн өсөлтөөс үүссэн сөрөг үр нөлөөлөл.

Төслийн эдийн засгийн ашиг тус нь Монгол улсад үндэсний хамжээний ач холбогдолтой байх болно. Монгол улсын Засгийн газар ба Оюу Толгойн аль алиных нь хувьд том сорилт бол эдгээр ашгийг шударгаар хуваарилах, Монголын эдийн засаг ба хүн амд тогтвортой үр ашигтай байх явдлыг хангахад хэрэглэгдэх баталгааг өгөхөд оршино.

Төслийн хаалтын үе шатанд нилээд хэмжээний сөрөг нийгэм эдийн засгийн нөлөөлөл байх магадлалтай байна. Төсөл нь маш урт хугацаанд үргэлжлэх тул (жишээлбэл, одоогийн төлөвлөлт нь одоогийн үйлдвэрлэлийн хүрээнд тодорхойлсон нөөцөд тулгуурлан уурхайг 27 жил ашиглах хугацаанд үндэслэсэн байхад эдийн засгийн судалгаанууд наад зах нь 59 жилийн уурхайн ашиглалтын хугацаанд үндэслэн хийгдсэн) уурхайн хаалтын үед давамгайлан байх нийгэм эдийн засаг, худалдаа ба улс төрийн нөхцөл байдлыг өнөөдрийн байдлаар урьдчилан хэлэх боломжгүй юм. Энэ асуудлыг Оюу Толгой нь байнгын хяналтандаа байлгаж хаалтын төлөвлөгөө нь тухайн цаг үеийн нөхцөл байдлыг тусгасан байх явдлыг баталгаажуулах хэрэгтэй юм. Төслийн эдийн засгийн оролцоо нь бүс нутгийн болон орон нутгийн эдийн засгийг нилээд хэмжээгээр бэхжүүлэх боломж олгох учраас тэр нь уурхайн хаалттай холбоотой болзошгүй сөрөг нөлөөллийг (төсвийн орлогын ба бусад төрлийн эдийн засгийн дэмжлэгийн тасралт зэрэг) тэсвэрлэх чадвартай болно гэж урьдчилан таамаглаж болно. Түүнээс гадна орон нутгийн байгууллагуудын өсөн нэмэгдэж бэхэжсэн чадавхи нь Төслийн ашиглалтын хугацаа дууссаны дараа орон нутгийн ард иргэдийг дэмжихэд ашиглагдах болно.

Доорхи Хүснэгт 7-4– т Оюу Толгой төслийн боломжит эдийн засгийн нөлөөлийг нэгтгэн үзүүлсэн.

Хүснэгт 7-4: Эдийн засгийн нөлөөллийн тойм

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөлийн ангилал	(4) Боломжит зэрэглэл	Төслийн төвлөлт ба нөлөөллийг бууруулах/сайжруулах арга хэмжээнүүд	Менежментийн төлөвлөгөө, бодлого ба журам	Үлдэгдэл нөлөөлийн зэрэглэл
Макро эдийн засгийн нөлөөлөл	Монгол улсын засгийн газар, Монгол улсын байнгын оршин суугчид ба бизнесийн байгууллагууд	Барилгын Үйлдвэрлэл Уурхайн хаалт	Хамрах хүрээ: Өргөн тархсан Хугацаа: Урт хугацааны Магадлал: Гарцаагүй	Эерэг	<ul style="list-style-type: none"> ■ Монгол улсын Татварын ерөнхий хууль ба нөөц ашигласны төлбөр төлөлтийн дүрмэнд нийцүүлэх ■ Монгол улсын Засгийн газрыг Олборлох салбарын ил тод байдлын санаачлага (ОСИТБС) – ыг хэрэгжүүлэхэд нь дэмжих³² ■ ОСИТБС – ын тайлан 	<p>ОСИТБС – ын тайланг Засгийн газар хэрэгжүүлнэ</p> <p>Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын Гэрээ (ХӨОГ) – гээр тохиролцсон арга хэмжээнүүд:</p> <ul style="list-style-type: none"> ■ Засгийн газраас байгуулсан Өмнийн говийн бүс нутгийн хөгжлийн зөвлөлийг хөрөнгө мөнгийг зарцуулахад нь дэмжлэг үзүүлэх: ■ 4.4.1. Орон нутаг ба бүс нутгийн хөгжлийг дэмжих ба ил тод хариуцлагатай засаглалыг сайшаах; ■ 4.4.6. Орон нутгийн засаг захиргаа болон иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; ■ 4.5. Өмнөговийн захиргаанаас хэрэгжүүлж байгаа нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлого, үйл ажиллагааг дэмжих ба Төслийн хэрэгжилтээс Монголын ард түмэнд тогтвортой ашиг хүрч байгаа гэдэг баталгаа өгөхийн тулд түншлэлийн харилцааг хөгжүүлэх ■ 4.13. ТББ – ууд, иргэний нийгэм, иргэний зөвлөл болон бусад оролцогч талуудтай ил тод байдал, хариуцлагатай байдал, нягт нямбай байдал, итгэл, хүндэтгэл болон харилцан ашиг сонирхлын зарчимд тулгуурласан бүтээлч ажлын харилцааг бий болгож бэхжүүлэх. 	Эерэг

³² Олборлох салбарын ил тод байдлын санаачлага (ОСИТБС) нөөцөөр баялаг улс орнуудад газрын тос, хий болон уул уурхайн салбарт оруулж байгаа компаний төлбөр ба засгийн газрын орлогыг шалгах ба бүрэн хэвлэн нийтлэх замаар ил тод байдал ба сайжирсан засаглалын дэлхийн стандартыг тогтоож байна. Эх сурвалж: <http://eiti.org/eiti>

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөлийн ангилал	(4) Боломжит зэрэглэл	Төслийн төлвлөлт ба нөлөөллийг бууруулах/сайжруулах арга хэмжээнүүд	Менежментийн төлөвлөгөө, бодлого ба журам	Үлдэгдэл нөлөөлийн зэрэглэл
Төгрөгийн өсөлт (Валютын ханш)	Монгол улсын засгийн газар, иргэд, бизнесийн байгууллагууд	Барилга Үйлдвэрлэл	Хамрах хүрээ: Өргөн тархсан Хугацаа: Дунд Магадлал: Магадлалтай	Дунд зэрэг сөрөг	<ul style="list-style-type: none"> Оюу Толгой төслийн дотоодын нийт бүтээгдэхүүнд нөлөөлөх нийт нөлөөлөл нь эерэг байхаар төсөөлөгдөж байна. Иймд төгрөгийн ханш чангарах байдлыг тэнцвэржүүлнэ. 	<p>Оюу Толгойн эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээнээс гарсан бодлогын санал, зөвлөмжүүд³³:</p> <ul style="list-style-type: none"> Ажилчдын хувийг ихэсгэж, гадаадад суугаа Монголчуудыг эргэн ирэхийг дэмжих; Оюу Толгойгоос орж ирэх санхүүгийн орлогод суурилан баялгийн хуримтлалын сан бий болгох. Үүнийг зөв зохистой зарцуулах; Бараа бүтээгдэхүүний экспортод хэт найдсан байдлаас сэргийлэхийн тулд валютын ханшийг уян хатан байлгах 	Бага хэмжээний сөрөг
Инфляци ба амьжиргааны өртгийн өсөлт	Монгол улс, аймаг ба сумын байнгын оршин суугчид Эмзэг бүлэгт орох магадлалтай хүмүүс: амьжиргааны түвшинээс доогуур амьдралтай, нийгмийн халамж үйлчилгээний тусламж хэрэгтэй иргэд, байнга халамжлах шаардлагатай хөгшид болог хүүхдүүд, тахир дутуу эсвэл хөдөлмөрийн чадавхгүй иргэд (18-24 настай), 18-аас доош насны өнчин хүүхдүүд, олон хүүхэдтэй ганц бие эх/эцэг	Барилга Үйлдвэрлэл	Хамрах хүрээ: Өргөн тархсан Хугацаа: Урт хугацааны Магадлал: Гарцаагүй	Их хэмжээний сөрөг	<ul style="list-style-type: none"> Ханбогд сумын хөдөлмөр, нийгмийн халамжийн газраас эмзэг хэмээн тодорхойлсон япуу/эмзэг өрх айлуудад чиглэсэн хөрөнгө оруулалтын зорилтот тусламж Хөрөнгө оруулалтын гэрээний 4.11-ний хэсгийн шаардлагын дагуу тодорхой түвшний сургалт болон хөдөлмөр эрхлэлтийг зохион байгуулах замаар хүн амын орлогыг бэхжүүлэх Оюу Толгойн Өмнийн говийн нийлүүлэлтийг дэмжих бодлогоор бараа, үйлчилгээг орон нутгаас худалдан авах Орон нутгийн бизнес болон эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрийн дагуу орон нутгийн бизнесийн хөгжлийн 	<p>Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын Гэрээ (ХӨОГ) – гээр тохиролцсон арга хэмжээнүүд:</p> <ul style="list-style-type: none"> 4.11. Өмнийн говийн бүс нутагт Өмнөговь аймагт давуу эрхтэйгээр орон нутгийн иргэдээс сургах, ажилд авах ба ажил эрхлэх давуу эрх. 8.4. Хөрөнгө оруулагчийн ажилчдын 90 – ээс багагүй хувь нь Монгол улсын иргэд байна. 8.5.1. Барилгын ажлын ба өргөтгөлийн ажлын хугацаанд ажилчдын 60%– иас багагүй нь Монгол улсын иргэд байна; Оюу Толгой төслийн сургалтын стратеги Оюу Толгойн Өмнийн говийн нийлүүлэлтийг хөгжүүлэх бодлого Оюу Толгойн Үндэсний нийлүүлэгчдийг хөгжүүлэх бодлого Монголчуудад давуу эрх олгох санаачлага Орон нутгийн бизнес эдийн засгийн хөгжил 	Дунд зэрэг сөрөг

³³ Оюу Толгойн зэсийн уурхайн хөгжил: Монгол улсын макро эдийн засагт үзүүлэх нөлөөллүүдийн үнэлгээ, 2011 оны 2 сар. МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль, BAEconomics Pty Ltd.

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөлийн ангилал	(4) Боломжит зэрэглэл	Төслийн төлвлөлт ба нөлөөллийг бууруулах/сайжруулах арга хэмжээнүүд	Менежментийн төлөвлөгөө, бодлого ба журам	Үлдэгдэл нөлөөлийн зэрэглэл
					<ul style="list-style-type: none"> ба ур чадварын сургалт ■ Орлого нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх (Нүүлгэн суурьшуулалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан) ■ Хэрэглэгчийн үнийн хяналт шинжилгээ 	<ul style="list-style-type: none"> (ОНБЭЗХ) – ийн хөтөлбөр ■ Г15: Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө ■ Г17: Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө ■ Г16: Хүн амын төвлөрөлийн менежментийн төлөвлөгөө 	
Улсын төсвийн орлогын өсөлт	Улсын, бүс нутгийн ба орон нутгийн байгууллагууд	Барилга Үйлдвэрлэл	Хамрах хүрээ: Өргөн тархсан Хугацаа: Дунд хугацааны Магадлал: Гарцаагүй	Эерэг	<ul style="list-style-type: none"> ■ Монгол улсын Татварын ерөнхий хуульд нийцүүлэх ■ Нөөц ашигласны төлбөр ба уул уурхайн лицензийн хураамж ■ Олборлолтын салбарын ил тод байдлын санаачлага (ОСИТБС) – ын хүрээнд засгийн газарт төлөх ил тод төлбөр ■ Байгууллагуудад төлөх татварын төлбөр: <ul style="list-style-type: none"> ○ Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар; ○ Хувь хүний орлогын албан татвар; ○ Гаалийн татвар ба акцизын татвар; ○ Нийгмийн даатгал (нийгмийн хангамж) – ын төлбөр ○ Газар ашиглалт ба түрээсийн төлбөр; ○ Үл хөдлөх хөрөнгийн татвар ба түрээсийн төлбөр; ○ Тэмдэгтийн хураамж ба бусад улсын 	<p>Өмнөд говийн бүс нутгийн хөгжлийн зөвлөл (ӨГБНХЗ) – ийг дэмжих Орон нутаг бүс нутгийн төлөвлөлт ба дэд бүтэц (ОНБНТДБ) – ийн санаачлага</p> <p>Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын Гэрээ (ХОГ) – нд тохиролцсон арга хэмжээнүүд:</p> <p>4.5. Өмнөд говийн орон нутгийн захиргаанаас хэрэгжүүлсэн нийгэм эдийн засгийн хөгжлийн бодлого ба үйл ажиллагааг дэмжих ба ОТ Төслөөс тогтвортой ашиг Монголын ард түмэнд үүний дотор Өмнөговь аймгийн ард түмэнд хүртэж байгаа гэдэг баталгаа өгөх түншийн харилцааг хөгжүүлэх.</p> <p>4.9. Хөрөнгө оруулагч орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ үүний дотор орон нутгийн хөгжил ба оролцооны санг байгуулахтай холбоотой гэрээ байгуулна</p> <p>Оюу Толгойн Орон нутаг бүс нутгийн төлөвлөлт ба дэд бүтэц (ОНБНТДБ) – ийн хэлтэс</p> <p>Орон нутгийн бизнес эдийн засгийн хөгжил (ОНБЭЗХ) – ийн хөтөлбөр</p>	Эерэг

Нөлөөлөл	(1) Нөлөөлөлд өртөгч	(2) Үе шат	(3) Нөлөөлийн ангилал	(4) Боломжит зэрэглэл	Төслийн төлвлөлт ба нөлөөллийг бууруулах/сайжруулах арга хэмжээнүүд	Менежментийн төлөвлөгөө, бодлого ба журам	Үлдэгдэл нөлөөлийн зэрэглэл
					татварууд; <ul style="list-style-type: none"> ○ Ус ашиглалтын хураамж; ба ○ Авто тээврийн хэрэгслэлийн татвар. ■ Орон нутгийн засаг захиргааны чадавхийг бэхжүүлэх сургалт, үүнд төсвийн менежмент ба ил тод байдлын тайлан 		

Тайлбар:

(1) Нөлөөлөлд өртөгч: Нөлөөлөлд өртсөн буюу бусад сонирхогч талуудыг хэлнэ

(2) Төслийн үе шатууд: С = Барилгын ажлын үе шат, О = Үйлдвэрлэлийн үе шат, D = Татан буулгалт ба Уурхайн хаалтын үе шат

(3) Нөлөөлийн ангилал:

Хугацаа: Богино хугацаа, Дунд хугацаа, Урт хугацаа

Хэмжээ: Зөвхөн орон нутгийн шинжтэй; Орон нутгийн шинжтэй; Өргөн тархсан

Магадлал: Магадлал маш багатай; Магадлал багатай; магадлалтай; Гарцаагүй

(4) Нөлөөллийн боломжит илрэх байдал: Их хэмжээний сөрөг; Дунд зэрэг сөрөг; Бага хэмжээний сөрөг; Нөлөөгүй; Эерэг

Орчуулгын үнэн зөвд баталгаа гаргахаас татгалзах тухай

Оюутолгой төслийн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг англи хэл дээр боловсруулж, монгол хэл рүү орчуулав.

Оюутолгой ХХК уг үнэлгээг монгол хэл рүү нягт нямбай, үнэн зөв орчуулахад хичээнгүйлэн ажилласан болно. Гэвч орчуулгын элдэв хүндрэлээс шалтгаалж, англи болон монгол хувилбарын хооронд ямар нэг зөрүү гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэв орчуулгын үнэн зөвтэй холбоотой ямар нэгэн эргэлзээ төрвөл баримт бичгийн албан ёсны хувилбар болох англи хувилбарыг уншина уу.

Оюутолгой ХХК нь орчуулгын үнэн зөв, бүрэн төгс байдлын талаар ямар нэг баталгаа гаргахгүй бөгөөд Оюутолгой ХХК нь орчуулгатай холбогдон шууд болон шууд бусаар үүссэн аливаа (Гэрээ, хэлцэл, гэм хорын дагуу буюу холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үүссэн г.м) хохирлыг хариуцахгүй болно.

Та уг орчуулгын алдаа, дутагдал болон орчуулгыг сайжруулах талаарх санал, зөвлөмжөө OTESIA@ot.mn хаягаар ирүүлнэ үү.